



МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙН ШИНЖИЛГЭЭ

Б.Аръяасүрэн¹, Б.Эрхэмбаяр²

¹ Монголбанкны Мөнгөний бодлогын газрын Эдийн засгийн шинжилгээ, бодлогын хэлтсийн эдийн засагч

Цахим шуудан: ariyasuren.b@mongolbank.mn

² Монголбанкны Мөнгөний бодлогын газрын Эдийн засгийн шинжилгээ, бодлогын хэлтсийн эдийн засагч

Цахим шуудан: erkhembayar.b@mongolbank.mn

Энэхүү судалгааны ажилд дурдагдсан санал, дүгнэлт нь зөвхөн хувь судлаачдын байр суурийг илэрхийлнэ. Тус судалгаатай холбоотой аливаа санал, зөвлөмж, шүүмжийг хүлээн авахдаа бид таатай байх болно.

ХУРААНГУЙ

Энэхүү судалгаагаар олон улсад өргөн ашиглагдаж буй өсөлтийн шинжилгээ хийх Хаусманн, Родрик, Веласко нарын “Шийдвэрийн горим”-ын аргачлалыг ашиглан Монгол улсын эдийн засгийн өсөлтөд саад болж буй асуудлуудыг тодорхойллоо. Судалгааны үр дүнгээс харахад манай орны хувьд хөрөнгө оруулалтын өгөөж бага, мөн санхүүжилтийн зардал өндөр байна. Хөрөнгө оруулалтын өгөөж бага байхад бүтээмж нэмэгдэхгүй байгаа, дэд бүтэц муутай, авилга өндөр, өмчийн эрхийг хамгаалах байдал муу, бодлогын дарамт өндөртэй, бүтээгдэхүүний захын хэмжээ бага, эдийн засаг төрөлжихгүй байгаа гэсэн хүчин зүйлүүд голлон нөлөөлж байна. Харин хөрөнгө оруулалтын зардал өндөр байхад хадгаламжийн түвшин хэлбэлзэл өндөртэй, хэмжээ багатай, банкны салбарын төвлөрөл өндөртэй, олон улсаас санхүүжилт авах зардал өндөр байгаа нь голлон нөлөөлж байна.

Түлхүүр үгс: Өсөлтийн шинжилгээ, шийдвэрийн горим

JEL ангилал: O4

УДИРТГАЛ

Манай орны эдийн засгийн өсөлтийг дундаас доош болон дундаас дээш бүлгийн орлоготой улсуудтай харьцуулахад эдийн засаг дунджаар 4.8 хувиар өсч байгаа нь бусад орнуудын түвшинд байгаа ч харьцангуй өндөр хэлбэлзэлтэй байна.

Эдийн засгийн өсөлт, бүлэг орнуудтай харьцуулснаар




Улс (1982-2018)	Дундаж өсөлт	Стандарт хазайлт
Дундаас доогуур орлоготой орнуудын дундаж	4.6	1.6
Дундаас дээгүүр орлоготой орнуудын дундаж	4.2	2.1
Монгол	4.8	5.3

Эх сурвалж: Дэлхийн банк


Эдийн засгийн өсөлтийг тогтвортой хадгалах, аливаа шокоос мэдрэг байдлыг бууруулах нь ядуурал, тэгш бус байдлыг бууруулахад чухал ач холбогдолтой. Тодруулбал, манай орны хувьд эдийн засгийн өсөлт өндөр байсан 2010-14 онуудад ядуурлын түвшин огцом буурсан байдаг. 2010 онд 3 хүн тутмын нэг нь ядуу байсан бол 2014 онд 5 хүн тутмын нэг нь ядуу болсон байдаг. Гэсэн хэдий ч 2016 онд нэг хүнд ногдох үйлдвэрлэл төдийлөн өсөөгүй тул ядуурлын түвшин ахин нэмэгдсэн байдаг. Ийнхүү одоогийн байдлаар Монгол орны 4 хүн тутмын нэг нь ядуу байгаа нь харьцангуй өндөр үзүүлэлт бөгөөд эдийн засгийн хүртээмжтэй, тогтвортой өсөлтийг хангах замаар ядуурлын түвшинг бууруулах шаардлагатай.

Нэг хүнд ноогдох ДНБ, худалдан авах чадварын паретитаар тооцсон³



Эх сурвалж: Дэлхийн банк

Ядуурлын түвшин, нийт хүн амд эзлэх хувиар



Эх сурвалж: YCX

Ядуурлын түвшин, тэгш бус байдлыг бууруулахад эдийн засгийн урт хугацааны хүртээмжтэй, тогтвортой өсөлтийг хангах нь чухал ач холбогдолтой. Иймд энэхүү судалгаагаар эдийн засгийн өсөлтийг урт хугацаанд тогтвортой, хүртээмжтэй болгоход ямар сорилтууд тулгарч байгааг тодорхойлохоор зорьлоо. Судалгаандаа Хаусманн, Родрик, Веласко нарын “Шийдвэрийн горим”-ын аргачлалыг ашиглахаар болсон бөгөөд энэхүү аргачлал нь яг тухайн орны эдийн засгийн өсөлтөд ямар хүчин зүйл саад болж байгааг тодорхойлох боломж олгодгоороо бусад судалгааны аргачлалуудаас давуу талтай. “Шийдвэрийн горим” аргачлал нь эдийн засаг яагаад хангалттай хэмжээний хөрөнгө оруулалт татаж чадахгүй байгаа вэ гэдэг асуултад хариулахыг зорьдог. Хангалттай санхүүжилт татаж чадахгүй байх нь i) хөрөнгө оруулалтын өгөөж бага ii) хөрөнгө оруулалтын зардал өндөр гэсэн аль аль хүчин зүйлээс хамаарч байна. Хөрөнгө оруулалтын өгөөж бага байхад далайд гарцгүй, бүтээмж өсөөгүй, дэд бүтэц муутай, авлигын түвшин өндөр, бодлогын дарамт өндөр, эдийн засаг төрөлжихгүй байгаа гэсэн олон хүчин зүйл нөлөөлж байна. Харин хөрөнгө оруулалтын зардал өндөр байгаа нь хадгаламжийн түвшин хэлбэлзэл өндөртэй, хэмжээ нь бага,

олон улсын санхүүжилтийн зардал өндөртэй гэсэн хүчин зүйлсээс шалтгаалж байна.

Энэхүү судалгааны ажил нь 6 үндсэн бүлэгтэй. I бүлэгт өсөлтийн шинжилгээ хийх аргачлалын талаар танилцуулна. Дараагийн бүлэгт өмнөх судлагдсан байдлыг товч дурдаж, III бүлэгт Монгол улсыг ямар орнуудтай харьцуулж байгаа талаар тайлбарлалаа. IV бүлэгт шинжилгээний хэсэг буюу эдийн засгийн өсөлтөд тухайн хүчин зүйл ямар нөлөөтэйг авч үзсэн. Ийнхүү V бүлэгт дүгнэлт, саналыг тусгасан.

1. ОНОЛ, АРГА ЗҮЙН ТАЙЛБАР

1.1 Өсөлтөд нөлөөлж буй хүчин зүйлсийн шинжилгээ

“Өсөлтөд нөлөөлж буй хүчин зүйлсийн шинжилгээ”-г ашиглаж эдийн засгийн өсөлтөд ямар хүчин зүйлс нөлөөлдөг болохыг тодорхойлдог. Сүүлийн үеийн судалгаануудад эдийн засгийн өсөлтийн шинжилгээ хийхэд үндсэн 3 арга ашиглаж байна (Ricardo Hausmann, 2008). Эдгээр нь:

- I. Олон улсын хүчин зүйлийн шинжилгээ
- II. Тухайн улсын хүчин зүйлийн шинжилгээ
- III. Бусад улсуудтай өөрийн орныг харьцуулан дүгнэх арга юм /Хүснэгт 1/.

“Олон улсын хүчин зүйлийн шинжилгээ”-ний аргачлалд сонгосон улсуудын панел тоон мэдээнд регрессийн шинжилгээ хийж, өсөлтөд дунджаар ямар хүчин зүйлс голлон нөлөөлж байгааг тодорхойлдог. Тухайлбал, 1960-95 оны 100 орны тоон мэдээг ашиглан хийсэн панел үнэлгээнээс харахад хуулийн өмнө эрх тэгш байдлын индекс 1 хувиар нэмэгдвэл 0.0172 нэгж хувиар, ардчилал эрх чөлөөний индекс 1 хувиар нэмэгдвэл 0.054 нэгж хувиар, иргэдийн сургуульд хамрагдсан хугацаа дунджаар 1 жилээр нэмэгдэхэд 0.0072 нэгж хувиар, хөрөнгө оруулалтын ДНБ-д эзлэх хувь 1 хувиар нэмэгдэхэд 0.059 нэгж хувиар, худалдааны нөхцөл 1 хувиар сайжрахад 0.165 нэгж хувиар тус тус эдийн засгийн өсөлт нэмэгддэг байна. Нөгөөтэйгүүр, засгийн газрын зардал (боловсролд зарцуулсан хөрөнгө оруулалтыг хасч тооцсон) 1 хувиар

нэмэгдэхэд 0.149 нэгж хувиар, инфляцийн түвшин 1 хувиар өсөхөд 0.037 нэгж хувиар эдийн засгийн өсөлт саарна (Barro, 1999). Тус шинжилгээний үр дүнг ашиглан өсөлтөд ямар хүчин зүйлс голлох нөлөөтэй байгааг мэдэх боломжтой ч тухайн нэг орны өсөлтөд ямар хүчин зүйл нөлөөлөхийг тодорхойлох боломжгүй байдаг тул энэхүү судалгаанд ашиглахад тохиромжгүй юм. Харин дараагийн аргачлал нь зөвхөн тухайн нэг улсын өсөлтийг олон хүчин зүйлээс хамааруулж тайлбарлахыг оролддог. Өөрөөр хэлбэл, “Тухайн улсын хүчин зүйлийн шинжилгээ”-нд тодорхой нэг улсын эдийн засгийн өсөлтийг биет капитал, хөдөлмөр, капитал болон хөдөлмөрөөс бусад хүчин зүйлийн бүтээмжээс хамааруулан тайлбарладаг. Энэ аргачлалыг ашиглахад эдийн засгийн хэд хэдэн томоохон таамаглалыг зөрчих, биет капитал хэмжих зэрэг хүндрэлтэй тулгардаг байна. Мөн өсөлтийг нэмэгдүүлэхийн тулд яг ямар арга хэмжээ авах шаардлагатай талаар тодорхой үр дүн өгдөггүй. Харин сүүлийн аргачлалд эконометрик аргачлал ашигладаггүй тул харьцангуй хялбар ч гадны томоохон байгууллагуудын судалгааны үр дүнг ашигладаг тул тэдгээр судалгааны чанараас ихээхэн хамаардаг. Гэсэн хэдий ч бусад орнуудтай харьцуулахад тухайн орны ямар үзүүлэлт муу байгааг тодорхойлох боломжтой тул энэхүү судалгаанд энэ аргачлалыг цаашид ашиглана.

Хүснэгт 1. Эдийн засгийн өсөлтийн шинжилгээ хийхэд ашиглаж буй аргууд

	Олон улсын хүчин зүйлийн шинжилгээ	Тухайн улсын хүчин зүйлийн шинжилгээ	Бусад улс орнуудтай харьцуулан дүгнэх
Аргачлал	Хэд хэдэн улсыг түүвэр болгон авч, тэдгээрийн нийгэм эдийн засгийн үзүүлэлтүүдийг ашиглаж өсөлтөд дунджаар ямар хүчин зүйл эерэгээр, ямар хүчин зүйлс сөргөөр нөлөөлж буйг регресс үнэлгээ хийж тодорхойлно.	Тухайн улсын өсөлтөд ямар хүчин зүйлс (биет капитал, хүмүүн капитал, хөдөлмөр, Солоугийн үлдэгдэл г.м.) нөлөөлж буйг регресс үнэлгээ хийж тодорхойлно.	Олон улсын томоохон байгууллагуудын хийсэн судалгааны үр дүнг ашиглан тухайн улсын нийгэм эдийн засгийн үзүүлэлтийг бусад улсуудтай харьцуулж, тухайн улсын өсөлтөд хамгийн их саад болж

			буй хүчин зүйлийг тодорхойлдог.
Сул тал	Шинжилгээнээс гарсан үр дүн тухайн улсын хувьд заавал үнэн байх албагүй. Жишээ нь: Дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх нь эдийн засгийн өсөлтөд томоохон эерэг нөлөө үзүүлэхээр үр дүн гарсан гэж үзье. Гэвч судалгаанд хамрагдсан дэд бүтэц сайтай орны хувьд дэд бүтцийн зардлыг нэмэгдүүлэх нь эдийн засгийн өсөлтөд төдийлөн нөлөө үзүүлэхгүй.	Энэхүү шинжилгээг хийхэд хүчин зүйл бүрийн хувьд өргөжилтийн тогтмол үр өгөөжтэй гэсэн таамаглал тавьдаг нь практикт нийцдэггүй. Мөн капиталыг хэмжих, хүчин зүйл бүрийн бүтээмжийг тооцох зэрэг хүндрэлүүдтэй тулгардаг. Өсөлтийн хэрхэн нэмэгдүүлэх гэхээсээ илүү аль хүчин зүйл өсөлтийг голлон бүрдүүлж байгааг тодорхойлохыг оролддог.	Судалгааны оролцогчид асуулгад субъектив шинжтэй хариу өгөх магадлалтай нь судалгааны чанар, ач холбогдлыг бууруулдаг.

1.2 Өсөлтийн шинжилгээ хийх HRV⁴ загвар


Энэхүү судалгааны ажилд өсөлтийн шинжилгээнд хамгийн өргөн ашиглаж буй Хаусманн, Родрик, Веласко нарын “Шийдвэрийн горим”-ыг ашиглаж ямар хүчин зүйл өсөлтөд саад болж байгааг тодорхойлно. Харин аль хүчин зүйл саад болж байгааг тодорхойлохдоо “Бусад улс орнуудтай харьцуулан дүгнэх” аргачлалыг ашиглана.

Өмнөх эдийн засагч судлаачид өсөлтөд нөлөөлж буй хүчин зүйлс орлох шинжтэй гэж үздэг бол HRV нь өсөлтийг тайлбарлагч гол хүчин зүйлүүд орлох гэхээс илүү хосолдог гэж үздэг (Ricardo Hausmann, 2008). Үүнийг Зураг 1-д харуулсан энгийн торхны жишээгээр баяжуулан тайлбарлая. Зүүн гар талын торхны банзнууд хөндлөн чигт байрласан (бие биенийгээ орлох боломжтой) бол баруун талын торхны банзнууд босоо чигт

⁴ Хаусманн, Родрик, Веласко нарын нэрний эхний үсгүүдийг нийлүүлсэн тэмдэглэгээ

байрласан (хүчин зүйлүүд хосолдог) гэсэн санааг илэрхийлж байна. Торхон дахь усны хэмжээг өсөлт гэж үзвэл зүүн талын торхны нийт усны хэмжээ нь банз бүрийн өргөний нийлбэртэй тэнцүү байна. Энэ нь өсөлтийн шинжилгээ хийх эхний хоёр аргатай төстэй юм. Өөрөөр хэлбэл өсөлтийг тайлбарлагч хүчин зүйлүүд бие биенийгээ орлох шинжтэй үед зарим үзүүлэлт муу байсан ч өөр үзүүлэлт сайн байвал эдийн засаг өсөх боломжтой. Харин өсөлтөд нөлөөлж буй хүчин зүйлс хоорондоо хосолдог бол баруун талын торхонд харуулснаар нийт усны хэмжээ нь хамгийн богино банзны өндөртэй тэнцүү байна. Энэ тохиолдолд торхтой усны хэмжээг нэмэгдүүлэхийн тулд хамгийн богино банзыг уртасгах шаардлага тулгардаг. Өөрөөр хэлбэл эдийн засгийн өсөлтөд чухал нөлөөтэй хүчин зүйл муу үзүүлэлттэй байвал бусад хүчин зүйлийг сайжруулж эдийн засгийг өсгөх гэж оролдсон ч зорилгодоо хүрч чадахгүй. Тиймээс эдийн засгийн өсөлт нэмэгдэхэд хамгийн ихээр саад болж буй хүчин зүйлийг олж илрүүлэх нь маш чухал асуудал болдог. Хэрэв олж илрүүлсэн асуудал нь өсөлтөд хамгийн ихээр саад болж байсан зүйл мөн бол түүнийг сайжруулснаар бий болох эерэг нөлөө нь хамгийн богино банз болон уртаараа түүний дараа орох богино банз хоорондын зайгаар илэрхийлэгдэнэ.

Зураг 1. Торхны жишээ



HRV загвар нь бусад өсөлтийн загваруудын адил “Хөрөнгө оруулалт эдийн засгийн өсөлтийг тэтгэдэг” гэж үздэг бөгөөд ямар хүчин зүйлээс

шалтгаалж хөрөнгө оруулалт бага байгааг тодорхойлох үндсэн зорилготой. Хөрөнгө оруулалтын хэмжээ цэвэр өгөөжөөс хамаардаг бөгөөд цэвэр өгөөжийн хэмжээ нь макро, микро олон хүчин зүйлээс хамаардаг. HRV загвараар өсөлтийн шинжилгээ хийхэд дараах шийдвэрийн горимыг ашигладаг.

Хүснэгт 2. Өсөлтийн шинжилгээний шийдвэрийн горим



Хөрөнгө оруулалт (аливаа төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх зардал)-ын өгөөж өндөр байвал эдийн засгийн өсөлт эрчимжинэ (Ricardo Hausmann, 2008). Өөрөөр хэлбэл, эдийн засгийн өсөлт нь хөрөнгө оруулалтын өгөөж болон зардлын зөрүү юм /Тэгшитгэл 1/. Иймд эдийн засгийн өсөлт бага байх нь i) хөрөнгө оруулалтын өгөөж бага байх ii) санхүүжүүлэх зардал бага байх гэсэн 2 хүчин зүйлээс шалтгаалдаг нь шийдвэрийн горимын эхний 2 салаа мөчир болдог. Үүнийг энгийнээр илэрхийлбэл, хэрэв хөрөнгө оруулалтын өгөөж бага байвал хөрөнгө оруулагчид эдийн засгийн өсөлтийг дэмжихүйц төслийг санхүүжүүлэхээс зайлсхийнэ. Нөгөөтэйгүүр, санхүүжилтийн зардал хэт өндөр байвал хөрөнгө оруулагчдын ашиг буурах тул эдгээр төслийг санхүүжүүлэх сонирхол буурна.

$$g = \sigma[r(1 - \tau) - \rho] \quad (1)$$

Энд: g – эдийн засгийн өсөлт, $r(1 - \tau)$ – хөрөнгө оруулалтын өгөөж, ρ – хөрөнгө оруулалтын зардал, σ – дискаунт фактор.

Хөрөнгө оруулалтын өгөөж i) Нийгмийн өгөөжийн түвшин, ii) Өгөөжийн эрсдэлээс голлон шалтгаалдаг. Нийгмийн өгөөжийн түвшин бага байх нь i) газар зүйн байршил ii) хүмүүн капитал муу байх iii) дэд бүтэц муу байхтай холбоотой. Харин өгөөжийн эрсдэл өндөр тохиолдолд хөрөнгө оруулалт хийгээд үр өгөөж хүртэхээсээ өмнө алдах эрсдэл өндөртэй байдаг тул хүмүүсийн хөрөнгө оруулах сонирхол буурдаг. Өгөөжийн эрсдэл өндөр байхад засгийн газрын алдаа, зах зээлийн хэмжээ бага гэсэн 2 хүчин зүйл нөлөөлдөг. Үүний засгийн газрын алдаа нь микро болон макро хүчин зүйлсээс голлон шалтгаална. Харин зах зээлийн хэмжээ бага байх нь мэдээллийн дам нөлөө, зохицуулалтын алдаанаас хамаарч байна. Модны баруун тал болох санхүүжилтийн зардал өндөр байхад i) Олон улсын захаас санхүүжилт авах өртөг ii) Дотоодын захаас санхүүжилт авах боломж зэргээс шалтгаалдаг. Дотоод захаас санхүүжилт авах боломж өндөр байх нь i) иргэдийн хадгаламжийн түвшин бага байх ii) санхүүгийн зуучлагчдын хүртээмж муу байгаагаас хамаардаг. Энд дурдсан хүчин зүйлс бүрийг дараагийн бүлгүүдэд тайлбарлаж ойролцоо орнуудтай харьцуулан дүгнэж, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэхийн тулд яг аль үзүүлэлтийг сайжруулах шаардлагатайг тодорхойлох нь судалгааны эцсийн зорилго юм.

Энэхүү аргачлал нь улс төрийн зардал, аливаа стратегийн шинэчлэлийн давуу талыг нарийвчлан тодорхойлоогүй бөгөөд улс төрийн саадыг давахад шаардлагатай сонголтуудыг илүү тодорхой болгоход тусална. Тус шинжилгээ нь голчлон богино хугацаанд өсөлтөд саад болж буй хүчин зүйлс дээр төвлөрнө. Өөрөөр хэлбэл маргааш эдийн засгийн өсөлтөд юу саад болохыг таамаглахгүй, өнөөдөр эдийн засаг өсөхөд юу саад болж байгааг тодорхойлдог тул энэхүү судалгааг 5 жил тутамд гүйцэтгэж шинэчлэх шаардлагатай.

2. СУДЛАГДСАН БАЙДАЛ

Олон улсад өсөлтийн шинжилгээ хийсэн судалгаанууд элбэг байдаг бөгөөд ихэвчлэн HRV аргачлалыг ашиглаж байна. Сүүлийн үед улс

орнуудын өсөлтөд саад болж буй хүчин зүйлийн шинжилгээ ихэвчлэн Мянганы сорилтын сангийн төслийн хүрээнд хийгдэж байна. Манай улсын хувьд өмнө нь хэд хэдэн удаа өсөлтийн шинжилгээ хийжээ. Тухайлбал 2007 онд Дэлхийн банкны Elena Ianchovichina, Sudarshan Goortu нарын судлаачид, 2010 онд АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн судлаачид, 2016 онд Мянганы сорилтын сангийн төслийн хүрээнд Монгол улсын өсөлтөд саад болж буй хүчин зүйлийг тодорхойлохыг оролджээ. Эдгээр судалгаануудын товч үр дүнг танилцуулбал:

Авлигал, зардал өндөртэй, найдваргүй тээврийн үйлчилгээ, хилийн болон худалдааны төвөгтэй дүрэм журмууд, татвар, дотоод, гадаадын хамтын ажиллагаа муутай зэргээс шалтгаалж барилга, уул уурхайгаас бусад секторт хөрөнгө оруулалт бага байна (Elena Ianchovichina, 2007). Мөн санхүүгийн зуучлалын үйлчилгээ муугаас үүдэн санхүүжилтийн өртөг өндөр байгаа нь өсөлтөд саад болж байна хэмээн дүгнэжээ.

Монгол улсын эдийн засагт i) Эдийн засгийн төрөлжилт муу ii) БНХАУ болон ОХУ-аас өндөр хамааралтай, iii) Инфляцийн түвшин өндөр iv) Санхүүгийн салбарын гүнзгийрэл, хүртээмж муу, v) Уул уурхайн салбар нийт ажиллах хүчинд хангалттай хэмжээний ажлын байр бий болгодоггүй тул ажилгүйдлийн түвшин өндөр байгаа, орлого тэгш бус нэмэгдэж байгаа, vi) Хүнсний аюулгүй байдал vii) Хүрээлэн буй орчны бохирдол /ус болон агаарын бохирдол, цөлжилт гэх мэт/ viii) Бодлогын ил тод бус байдал, төрийн байгууллагын ажилчдын чадвар муу, авлига өндөр зэрэг асуудлууд байгаа талаар дурджээ (Alan Saffery, 2010).

i) Сул, тогтворгүй макро эдийн засгийн орчин, ii) Хоорондоо уялдаа муутай хууль журам, төрийн бодлого, iii) Улаанбаатарын агаарын бохирдол, iv) Бүтээмж өндөртэй салбаруудад ус, бохир ус зайлуулах системд холбогдох зардал өндөртэй байгаа зэрэг нь эдийн засгийн өсөлтийг боомилж буй гол хүчин зүйлүүд хэмээн дүгнэжээ (Millennium Challenge Corporation, 2016).

3. ХАРЬЦУУЛЖ БУЙ ОРНУУД

Энэхүү судалгаанд ашиглаж буй арга нь бусад улсуудтай өөрийн орныг харьцуулан дүгнэдэг тул судалгааны нэг чухал хэсэг нь харьцуулах улс орнуудыг зөв сонгох явдал юм. Өөрийн оронтой ижил төстэй шинжтэй орнуудыг сонгохын тулд эхлээд өөрийн улсын онцлогийг таних нь зүйтэй. Манай орон нь далайд гарцгүй, түүхий эдийн экспортод өндөртэй зэрэг нь хамгийн онцлог шинжтэй. Үүн дээр нэмэгдээд нийтлэг ашиглагддаг арга болох нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ ойролцоо, олон улсын өрсөлдөх чадварын индекс ойролцоо орнуудыг сонгосон. Улмаар эдгээр 4 ангилал тус бүрт хамаарах орнуудыг нэгтгэн бүлэглэснээр өөрийн орныг харьцуулж болохуйц 4 бүлэг улсыг үүсгэсэн. Ангилал бүрт хамаарах орнуудыг дараагийн хүснэгтэд дэлгэрэнгүй харууллаа.

Хүснэгт 3. Монгол улстай харьцуулж болох орнууд, шалгуур үзүүлэлтээр

	Далайд гарцгүй орнууд	Түүхий эдийн экспорт өндөртэй орнууд	Өрсөлдөх чадварын индекс ойролцоо орнууд	Нэг хүнд ногдох ДНБ ойролцоо орнууд (ОУ-ын доллараар)
1	Австри	Армен (37%)	Босни Герцеговини (92-р байр)	Армен (10176\$)
2	Азербайжан	Гана (31.8%)	Гана (111-р байр)	Боливи (7477\$)
3	Боливи	Казахстан (34.3%)	Доминикан (78-р байр)	Босни Герцеговини (13491\$)
4	Ботсвана	Киргизстан (32.7%)	Египет (93-р байр)	Египет (13366\$)
5	Казахстан	Мали (22.3%)	Киргизстан (96-р байр)	Иордан (9433\$)
6	Молдав	Мауратини (43.1%)	Ливан (88-р байр)	Ливан (14684\$)
7	Непал	Өмнөд Африк (30%)	Пакистан (110-р байр)	Өмнөд Африк (13675\$)
8	Туркменистан	Перу (25.2%)	Сенегал (114-р байр)	Перу (14224\$)
9	Узбекистан	Танзани (15%)	Тунис (87-р байр)	Эсватини (11020\$)
10	Унгар	Узбекистан (29.1%)	Монгол (102-р байр)	Монгол (13447\$)
11	Чех	Чили (28.8%)		
12	Эсватини			

Тоо мэдээнээс шалтгаалж зарим хэсэгт тодорхой улсуудыг сонгож харьцуулах бол ихэнх тохиолдолд дээрх 4 бүлэг улсын дундажтай өөрийн орныг харьцуулан дүгнэнэ. Ангиллаас харвал Армен, Казахстан, Босни Герцеговини, Египет, Өмнөд Африк, Боливи, Гана, Киргизстан, Перу, Ливан, Узбекистан зэрэг 11 улс хоёр ангилалд давхацаж орсон байна. Ийнхүү олон давхцсан байгаа нь манай улстай илүү төстэй эдийн засаг болохыг илтгэнэ.

4. ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭСЭГ

4.1 Тоо мэдээ

Судалгаанд ашигласан тоо мэдээний ихэнх нь олон улсын байгууллагуудаас гаргасан улс орнуудыг хооронд нь харьцуулсан тайлангууд байгаа бөгөөд Монгол улстай холбоотой тоо мэдээг ҮСХ, Сангийн яам, Монголбанкны тайлан мэдээнээс авч нэгтгэсэн. Тодруулбал:

- Дэлхийн банкны аж ахуй нэгжүүдийн судалгаа (2018)
- Дэлхийн банкны Бизнесийн орчин болон үйлдвэрийн газрын үйл ажиллагааны судалгаа (2018)
- Дэлхийн өрсөлдөх чадварын тайлан (2018)
- Транспэрэнси интернэшнл байгууллагын авилгалын хамрагдлын индекс (2018)

зэрэг тайлангуудаас ихэнх харьцуулах үзүүлэлтүүдээ авсан.

4.2 Шийдвэрийн горимын шинжилгээ

Шийдвэрийн горимын зүүн тал

Санхүүжилтийн зардал бага (дотоод болон гадаад зээлийн хүү бага) байсан ч хөрөнгө оруулалтын өгөөж хангалтгүй байгаагаас шалтгаалж хөрөнгө оруулалт нэмэгдэхгүй байж болно. Хөрөнгө оруулалтын өгөөж бага байх нь i) нийгмийн өгөөж бага, ii) хөрөнгө оруулалтын эрсдэл өндөр байгаагаас шалтгаалдаг. Тухайлбал, хөрөнгө оруулагч аливаа төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэхийн өмнө газар зүйн байршил, хөрөнгө оруулалтын эрсдэл, макро тогтвортой байдал зэрэг хүчин зүйлийг харгалзан үзэж шийдвэрээ гаргадаг. Жишээ нь: тухайн улс дотроо улс

төрийн зөрчилдөөн өндөр, макро эдийн засаг нь тогтворгүй байвал гадны хөрөнгө оруулагчид тэр улсад төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхгүй байх магадлал өндөр.

1.1.1 Газар зүйн байршил

Манай улс ОХУ, БНХАУ-ын хооронд далайд гарцгүй, хүн амын нягтшил багатай онцлогтой. Хамгийн ойрын далайн боомт 1000 гаруй километр зайтай байрладаг. Газар хөдлөлт, далайн шуурга, үер, шуурга зэрэг байгалийн гамшигт үзэгдэл тохиох эрсдэл багатай орнуудын тоонд ордог. Хэдийгээр байгалийн гамшигт үзэгдэл бага ч цаг уурын эрс тэрс байдал, далайд гарцгүй зэрэг нь эдийн засгийн өсөлтөд томоохон сорилтыг бий болгодог. Далайд гарцгүй орнууд i) хөдөлмөрийн гадаад шилжих хөдөлгөөн хийхэд хүндрэлтэй ii) улсын хилийн дагуух дэд бүтцийг сайжруулахад төвөгтэй iii) хөрш орнууд нь цэргийн болон эдийн засгийн зорилгоор далайд гарцгүй орнуудад торгууль ноогдуулах гол хүндрэлүүдтэй тулгардаг (John Luke Gallup, 1999). Газар зүйн байршил эдгээр хүндрэлийг учруулж байгаа ч үүнийг шийдвэрлэх ямар нэг бодлогын сонголтгүй юм. Гэвч өөрсдийн газар нутгийн байрлал, давуу болон сул талыг мэдэж байх нь бодлого боловсруулагчдад чухал мэдээлэл билээ.

1.1.2 Хүмүүн капитал

Хүмүүн капиталыг нарийвчлан хэмжихэд төвөгтэй байдаг ч үйлдвэрлэлийн чухал орц тул эдийн засгийн өсөлтөд чухал ач холбогдолтой. Хэдийгээр хүмүүн капиталыг ур чадвар, оюун ухаан, бүтээлч сэтгэлгээ, технологи зэргээр тодорхойлдог ч эдгээр хүчин зүйлсийг хэмжих боломжгүй. Бусад судалгааны ажлуудад хүмүүн капиталыг хэмжихдээ сургуульд сурсан дундаж хугацаа, боловсролд зарцуулсан зардал зэрэг үзүүлэлтийг авч үзсэн байдаг. Энэхүү жишгээр 25-с дээш насны хүмүүсийн сургуульд хамрагдсан хугацааг ойролцоо орлоготой орнуудтай харьцуулан харвал манай улсын сургуульд хамрагдсан хугацаа харьцангуй өндөр буюу 2015 оны байдлаар дэлхийд 41-р байранд байна. Манай улсын иргэд дунджаар 10 жилийн


боловсролтой байгаа нь ихэнх хүмүүс бүрэн дунд боловсрол эзэмшсэнийг илтгэж байна /Зураг 3/.

Зураг 3. Ойролцоо орлоготой орнуудын 25-с дээш насны хүн амын сургуульд суралцсан дундаж хугацаа (2015)

Улс	25+ насны хүн амын сургуульд суралцаж буй хугацаа	Эрэмбэ
Эсватини	12.1	8
Армен	10.6	33
Боливи	10.6	35
Монгол	10.1	41
Орос	9.9	44
Перу	8.9	58
Иордан	8.7	63
Өмнөд Африк	8.4	69
Хятад	8	79
Египет	7.7	85

Эх сурвалж: Дэлхийн банк

Зураг 4. Монгол орны 25-с дээш насны хүн амын сургуульд суралцсан дундаж хугацаа, насны бүлгээр (2015)




Эх сурвалж: Дэлхийн банк

Монгол улсын боловсролын салбарт зарцуулж буй хөрөнгө оруулалт нь ДНБ-ий 4 орчим хувийг эзэлж байгаа нь харьцуулж буй орнуудын ихэнхээс өндөр, дэлхийн дундажтай ойролцоо байна /Зураг 5/. Хэдийгээр боловсролын түвшин харьцангуй өндөр, боловсролд зарцуулж буй хөрөнгө оруулалтын хувь хэмжээ өндөр байгаа ч боловсролтой иргэдийн дунд ажилгүйдлийн түвшин өндөр, боловсролгүй иргэдийн ажиллах хүчний оролцооны түвшин бага байна. Өөрөөр хэлбэл, “Ажиллах хүчний судалгааны үндсэн тайлан (2018)”-нд дурдсанаар ажилгүй иргэдийн дийлэнх нь ажил хайгаад олдохгүй (48.5%), мэргэжилд тохирох ажил олдохгүй (12.9%), ажил олгогчийн тавьсан шаардлагад тэнцэхгүй байгаа (3.7%) зэрэг шалтгаанаар хөдөлмөр эрхлээгүй байна. Нөгөөтэйгүүр, ажил олгогчид шинээр

ажилтан авахад ажлын туршлагагүй (22.2%), тогтвортой ажиллах хүсэлгүй (18.2%), ажлын байрны нөхцөл, цалинг голдог (17.1%), ажлын ачаалал даах чадваргүй (13.1%), боловсролын түвшин ажлын байрны шаардлагад нийцэхгүй (8.8%) гэсэн сорилтуудтай тулгардаг⁵. Үүнээс үзэхэд манай орны боловсролын систем эрэлттэй ажил мэргэжлээр боловсон хүчин бэлтгэж чаддаггүй байх талтай юм. Нөгөөтэйгүүр, өндөр боловсролтой хүмүүс ажлын байрны нөхцөл, цалингаа голох магадлал илүү өндөр тул эдгээр иргэдийн дунд ажилгүйдлийн түвшин өндөр байна. Энэ нь боловсролын өгөөж бага байгааг илтгэх тул цаашид хэчнээн боловсролд зарцуулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлсэн ч үр ашиггүй болохыг харин иргэдийн ур чадварыг нэмэгдүүлэх чиглэл боловсролын хөрөнгө оруулалтыг чиглүүлэх шаардлагатайг илтгэж байна.

Зураг 5. Боловсролын салбарт оруулж буй хөрөнгө оруулалт, ДНБ-д эзлэх %



Эх сурвалж: Дэлхийн банк

Зураг 6. Ажилгүйдлийн түвшин, боловсролын түвшингээр 2018 он



Эх сурвалж: УСХ

⁵ Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаа (2018)

Хүний хөгжлийн индексийн 2017 оны үр дүнгээс харвал Монголд эрэгтэй хүмүүсийн хүлээгдэж буй боловсрол эзэмших хугацаа 15 жил байгаа бол эмэгтэй хүмүүсийнх 15.9 жил байна. Энэхүү үзүүлэлт нь Монгол улсад шинээр төрж буй хүүхэд дунджаар бакалаврын зэргийн боловсрол эзэмшихээр хүлээгдэж байгаа сайн үзүүлэлт юм. Гэвч “Өрсөлдөх чадварын тайлан 2018”-гийн үр дүнгээс харахад Монгол улс хүмүүн капиталын үзүүлэлтээр дэлхийд 99-р байранд буй нь боловсролд зарцуулж буй хугацаа өндөртэй орны хувьд чамлахаар дүн юм.

Ажилгүйдлийн түвшин өндөр, хүмүүн капиталын үзүүлэлтүүд дундаж байгаа зэргээс үзэхэд манай орон хөдөлмөрийн нөөцөө үр ашигтай ашиглаж чадахгүй байна. Өөрөөр хэлбэл, боловсролд зарцуулж буй хөрөнгө оруулалт өндөр ч эрэлттэй мэргэжлээр боловсон хүчинг бэлтгэх тал дээр дутмаг, энэ талын бодлогын арга хэмжээ шаардлагатай байна. Эдгээр асуудлуудыг шийдвэрлэж, хүмүүн капиталын үзүүлэлтийг сайжруулах шаардлагатай байгаа ч манай орны иргэдийн боловсрол, ур чадвар эдийн засгийн өсөлтөд хамгийн их саад болж байна гэж дүгнэх үндэслэлгүй байна. Учир нь сүүлийн жилүүдэд хүмүүн капиталын үзүүлэлтүүдэд гэнэтийн огцом өөрчлөлт гараагүй бөгөөд тус хугацаанд эдийн засгийн өсөлт өндөр далайцтай хэлбэлзэж байсан юм. Иймд боловсролд зарцуулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх гэхээс илүүтэй боловсролын чанарыг сайжруулах шаардлагатай.

1.1.3 Бүтээмж⁶


Манай орны эдийн засгийн өсөлт нь биет хөрөнгийн хуримтлалаас голлон шалтгаалж байгаа бол бүтээмж төдийлөн нэмэгдэхгүй байна /Зураг 3, 4/. Ерөнхийдөө, машин тоног төхөөрөмжийн хуримтлал, дэд бүтэц сайжрах, ажилчдын ур чадвар нэмэгдэх, технологийн дэвшил гарах зэрэгтэй холбоотойгоор бүтээмж нэмэгддэг⁷. Өөрөөр хэлбэл, бүтээмж нь хөдөлмөр болон бусад үйлдвэрлэлийн орцууд хоорондоо

⁶ Энд хөдөлмөрийн бүтээмж гэдэг нь нэг ажилтанд ногдох үйлдвэрлэлийн өсөлт (биет хөрөнгийн нөлөөг хассан)-ийг авч үзсэн болно.

⁷ OECD (2001), OECD Manual Measuring Productivity Measurement of aggregate and industry-level productivity growth


хэрхэн уялдаж, хэр үр ашигтай үйлдвэрлэл явуулж байгаа, технологийн дэвшил эдийн засагт хэр хурдан нэвтэрч байгаа зэргээс хамаардаг. Иймд бүтээмжийг нэмэгдүүлэх, нөөц ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэх нь эдийн засгийн өсөлтөд чухал ач холбогдолтой байна.

Зураг 3. Эдийн засгийн өсөлт



Эх сурвалж: Дэлхийн банк Монголын эдийн засгийн тойм 2018

Зураг 4. Монгол орны бүтээмж, индексээр



Эх сурвалж: University of Groningen

Дэд бүтэц

Олон улсын өрсөлдөх чадварын тайлангаас харахад Монгол улсын дэд бүтэц харьцуулж буй орнуудаас муу байна. Тухайлбал, тээврийн салбарын замын үзүүлэлтээр 111-р байранд, төмөр замын үзүүлэлтээр 74-р байранд, 1 км² талбайд ногдох төмөр замын уртаар 94-р байранд, агаарын тээврийн үзүүлэлтээр 110-р байранд, замын чанарын үзүүлэлтээр 105-р байранд байна. Нийт хүн амын 91.6 хувийг цахилгаан, эрчим хүчээр хангаж чадаж байгаа нь дэлхийд 99-р байранд орох үзүүлэлт юм. Мөн усны дэд бүтцийн үзүүлэлтээр дэлхийд 95-р байранд, усны нөөцөөр хангагдсан байдлын үзүүлэлтээр 100-р байранд орсон байна. Гэх мэтчилэн дэд бүтцийн ихэнх үзүүлэлтүүдээр дэлхийн улсуудын дундуур эсвэл дундаас хойгуур байрыг эзэлж байгаа нь манай улсын дэд бүтэц хангалтгүй байгааг илэрхий харуулж байна.

Хүснэгт 4. Дэд бүтцийн үзүүлэлтүүд, зарим оронтой харьцуулснаар

Дэд бүтэц	Мэдээлэл харилцааны технологи				Эрчим хүч		Тээврийн дэд бүтэц	
	Оноо	Эрэмбэ	Оноо	Эрэмбэ	Оноо	Эрэмбэ	Оноо	Эрэмбэ
Хятад	78.1	29	71.5	26	99.4	20	68	23
Орос	72.2	51	72.1	25	96.8	56	55	52
Эсватини	58.8	94	24.9	125	89.1	99	42.1	88
Армен	66.3	74	59.2	56	95.6	69	44.5	81
Боливи	56.2	102	45.7	87	92.9	91	29.3	126
Иордан	66.6	73	52.3	75	96.3	63	45.4	78
Өмнөд Африк	68.6	64	46.1	85	91.1	98	57.5	43
Перу	62.4	85	43.9	94	93.9	83	39	96
Египет	70.5	56	40.6	100	96.2	64	54	56
Босни	60.7	89	45.8	86	96.7	58	36	104
Ливан	58.5	95	57	59	96.7	57	42.9	86
Монгол	56.2	103	48.7	78	91.7	97	32.9	113

Эх сурвалж: World Economic Forum “The Global Competitiveness Report 2018”

Далайд гарцгүй Монгол улсын хувьд авто болон төмөр замын дэд бүтцийг сайжруулах нь нүүрс, төмрийн хүдэр зэрэг эрдэс бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Зарим чиглэлд төмөр зам байхгүйгээс шалтгаалж нүүрс экспортлохдоо авто замын тээврийг ашигладаг нь зардал өндөр, үр ашиг муутай байдаг. Энэхүү тээвэрлэлтийн хүндрэл, зардлын асуудал нь экспортын өсөлтийг хязгаарлах цаашилбал экспортын секторт хөрөнгө оруулах сонирхлыг бууруулах эрсдэлтэй. Европын сэргээн босголт, хөгжлийн банкнаас хийсэн Монголын хөгжлийн стратеги (2017)-д “Монгол орны дэд бүтцийг шинэчлэн хөгжүүлэх нь уул уурхайн болон бусад аж үйлдвэрийн эрэлтийг хангах, эрдэс бүтээгдэхүүний экспортыг хөнгөвчлөх, уул уурхайн бус салбарын хөгжлийг дэмжих чухал ач холбогдолтой талаар дурдсан. Мөн тээвэр, орон нутаг болон эрчим хүчний дэд бүтэц хангалттай хөгжөөгүй, хууль эрх зүйн зохицуулалт муутай, төрийн өмчит (үр ашиг муутай), хувийн байгууллагууд нэвтэрч орох бололцоотой байгаа гэжээ. Тиймээс дэд бүтцийг сайжруулах нь уул

уурхайн болон уул уурхайн бус бүх салбаруудад чухал ач холбогдолтой байна.

1.2.1.1 Микро эрсдэлүүд

Гэмт хэрэг болон авлига

Ойролцоо орлоготой орнуудтай харьцуулахад Монгол улсын гэмт хэргийн түвшин харьцангуй бага байгаа ч авлигын түвшин өндөр байна. “Транспэрэнси интернэшнл” байгууллагаас гаргасан 2018 оны тайлангаас харвал авлигын түвшнээр Монгол улс нийт 100 онооноос 37 оноо авч дэлхийн 180 орноос 93-р байранд байна.

Монгол орны хувьд бага хэмжээтэй авлига буурч байгаа хэдий ч төрийн үйлчилгээ, улс төрийн авилга өндөр хэвээр байна. Улс төрийн нам, засгийн газрын хүрээнд танил талаа ашиглан ажилд орох нь иргэд болон бизнесийн орчны итгэлийг бууруулж байна (Transparency International Mongolia, 2018). Монголын ихэнх компаниуд бизнесийн орчинд ямар нэг байдлаар сэтгэл дундуур байдаг (Asia Foundation , 2017b) тул тэдгээрийн хөрөнгө оруулах сонирхол харьцангуй бага байх талтай⁸.

Монгол улс “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга”-д 2007 онд элсэн орж, уул уурхайн салбарын ил тод байдлыг нэмэгдүүлэхэд тодорхой хэмжээний ахиц гаргаад байгаа ч тус салбар авилгаас ихээхэн хамааралтай байна. Тодруулбал, олборлолт хийх газрын лицензийн талаар хуулинд нарийн тусгаагүй тул газрын лиценз олгох үйл явц нь улс төрийн нөлөөнд автдаг бөгөөд тус асуудлаар ил тод байдал муу байдаг (Transparency International, 2018).


Гэмт хэрэг багатай ч авлигын үзүүлэлтүүд дорвитой сайжрахгүй байгаа нь, тэр дундаа эдийн засгийг нуруундаа үүрч яваа уул уурхайн салбарт элбэг байгаа нь авлига эдийн засгийн өсөлтөд тушаа болж байна гэж

⁸Дундаас дээш орлоготой орнуудын хувьд хувийн секторт олгож буй зээлийг ДНБ-тэй харьцуулахад дундажаар 115 орчим хувь бол Монгол орны хувьд энэ харьцаа 56 хувь байна.

дүгнэх үндэслэл болж байна. Гэвч өсөлтөд хамгийн их саад болж буй хүчин зүйл биш юм.

Зураг 9. Гэмт хэрэг болон авлигын үзүүлэлтүүд

9а) Гэмт хэрэг болон хулгайн үзүүлэлт⁹




Эх сурвалж: ICA
Worldbank 2017

9б) Авлигын үзүүлэлт



Эх сурвалж: ICA
Worldbank 2017

9в) Авлигын үзүүлэлт¹⁰



Эх сурвалж: The Index of
Economic Freedom, The Heritage
Foundation

Татвар

Монгол улсын татварын түвшинг бусад орнуудтай харьцуулахад тогтвортой, харьцангуй бага байна. Энд манай улсын аж ахуйн нэгжийн татвар бага байгаа нь хувийн секторын хөрөнгө оруулалтад учруулах татварын дарамт бусад орнуудаас бага байгааг илтгэж байна.

⁹ Энэ үзүүлэлт өндөр байвал гэмт хэрэг их байгааг илтгэнэ.

¹⁰ Энэхүү авилгын индекс бага байх тусам авилга өндөр байгааг илэрхийлнэ.

Хүснэгт 5. Улс орнуудын татварын түвшин

Улс	ААН-ын татвар	Хувь хүний орлогын албан татвар (ХХОАТ)	Нэмүү өртөгийн татвар
Монгол	10%	10%	10%
Босния	10%	10%	17%
Ливан	17%	3%-20%	11%
Иордан	20%	0%-14%	16%
Орос	20%	13%-47%	20%
Армен	20%	24.4%-36%	20%
Египет	22.5%	0%-22.5%	14%
Хятад	25.0%	0%-45%	16%
Эсватини	27.5%	33%	14%
Өмнөд Африк	28%	0%-45%	15%
Перу	30%	0%-30%	16%

Эх сурвалж: Deloitte, USCIB

Энд: Монгол оронтой орлогын түвшинээр ойролцоо түвшинд байгаа орнууд болон хил залгаа орших Хятад, Оросын татварын түвшинг харуулсан.

Татвар төлөхөд учирч буй дарамтыг i) нэг жилд төлөх нийт татварын тоо, ii) эдгээр татварыг төлөхөд зарцуулж буй нийт хугацаа, iii) нийт ашигт эзлэх татварын хувь, iv) НӨАТ-ын буцаан олголт авахад хэр зэрэг хүндрэлтэй зэргээс хамааруулж тооцдог. Манай оронд төлж буй нийт татварын тоо харьцангуй олон, НӨАТ-ын буцаан олголт авахад хүндрэлтэй байна. Харин татвар төлөхөд зарцуулж буй хугацаа, нийт ашигт эзлэх татварын хувь харьцангуй бага байгаа нь эерэг үзүүлэлтүүд юм.

Хүснэгт 6. Татвар төлөхөд учирч буй дарамтын үзүүлэлт, бусад орнуудтай харьцуулснаар


Үзүүлэлт	Монгол	Зүүн Ази, Номхон далайн бүс	Зүүн өмнөд Азийн бүс нутаг	Хамгийн сайн үзүүлэлттэй орон
Нийт татварын тоо (1 жилд)	19	21.2	11.2	3 (Хонк-Конг)
Нийт зарцуулж буй хугацаа, хоногоор	134	180.9	159.4	49 (Сингапур)
Нийт ашигт эзлэх татварын хувь	24.7	33.5	39.8	26.1 (32 орны дундаж)
НӨАТ-ын буцаан олголтын индекс ¹¹	49.08	56.42	84.41	NA

Эх сурвалж: Бизнес эрхлэхэд хялбар байдлын судалгаа: Монгол (2019), Дэлхийн банк

¹¹ Энэхүү үзүүлэлт нь аудитад орох, НӨАТ-ын буцаан олголтыг авахад хэр зэрэг хүндрэлтэйг илтгэнэ.

Улмаар татварын дарамтын нийлбэр үзүүлэлтээр дэлхийд 61-р байранд байгаа нь хөрш болон ойролцоо орлоготой орнуудтай харьцуулахад харьцангуй сайн үзүүлэлт юм.

Зураг 10. Татварын дарамтын оноо болон эрэмбэ




Эх сурвалж: Бизнес эрхлэхэд хялбар байдлын судалгаа, Дэлхийн банк (2019)

Иймд татварын түвшин болон татварын дарамтын үзүүлэлт бусад орнуудтай харьцуулахад бага түвшинд байгаагаас үзэхэд татварын дарамт эдийн засгийн өсөлтөд саад болохгүй байна.


Өмчийн эрх

Зураг 11. Өмчийн эрхийн индекс¹², харьцуулж буй улсуудын бүлгээр



Эх сурвалж: *The Index of Economic Freedom, The Heritage Foundation*

Зураг 12. Өмчийн эрхийн индекс, дэлхийн улсуудаар



Эх сурвалж: *The Index of Economic Freedom, The Heritage Foundation*

Өмчийн эрх хамгаалах байдал 2005 оноос хойш огцом муудсан ч 2017 оноос эргэн сайжирсан байна (Зураг 11). Энэ нь харьцуулж буй улсуудтай ойролцоо байгаа ч дэлхийн бусад улс орнуудтай харьцуулахад муу гэсэн ангилалд багтаж байна. (Зураг 12). Хэдийгээр өмчийн эрхийн индекс сүүлийн жилүүдэд муудсан ч тухайн хугацаанд манай орны эдийн засаг түүхэнд байгаагүй өндөр хувиар өссөн¹³ байдаг. Үүнээс үзэхэд өмчийн эрхийн асуудал эдийн засгийн өсөлтөд хамгийн их саад болж буй хүчин зүйл биш юм.

1.2.1.2 Макро эрсдэлүүд

Засгийн газрын бодлогын дарамтын үзүүлэлтээр 104-р байранд буюу харьцуулж буй орнуудаас ихэнхээс нь муу үзүүлэлттэй байна. Тодруулбал, манай улсын засгийн газрын бодлогын тогтвортой байдал

¹² Энэхүү индекс өндөр байх тусам өмчийн эрхийг илүү сайн хамгаалдаг болохыг илэрхийлнэ.

¹³ 2011 онд манай орны эдийн засаг түүхэнд байгаагүй өндөр хувиар буюу 17.3 хувиар өссөн.

болон уялдаа муу, аливаа өөрчлөлтөд уян хатан бус, ирээдүйд чиглэсэн бодлого хангалтгүй байгаа нь харагдаж байна /Хүснэгт 7/. Энэхүү байдал нь бизнес эрхлэгчдийн дунд тодорхой бус байдлыг үүсгэх тул хөрөнгө оруулах сонирхлыг бууруулж макро эдийн засгийн тогтворгүй байдлыг бий болгож байна.


Хүснэгт 7. Засгийн газрын бодлогын үнэлгээ, харьцуулж буй улсуудаар

	Засгийн газрын бодлогын дарамт		Бослогыг намжаах хууль эрх зүйн орчин		Цахим ертөнц дэх иргэдийн улс төрийн хандлага		Ирээдүйд чиглэсэн бодлого		Бодлогын тогтвортой, уялдаатай байдал	Бодлогын өөрчлөлтөд уян хатан байдал
	Оноо	Эрэмбэ	Оноо	Эрэмбэ	Оноо	Эрэмбэ	Оноо	Эрэмбэ	Эрэмбэ	Эрэмбэ
Хятад	56.3	18	51.9	47	90.5	29	56.3	32	43	36
Орос	39.1	73	42.1	78	92.1	23	47.9	54	81	46
Эсватини	44.3	54	41.3	81	33.2	121	35.9	106	69	118
Армен	47	41	45.1	68	56.7	97	47.3	61	82	56
Боливи	18.3	137	17.7	138	57.9	93	20.9	134	136	127
Иордан	42.9	60	56.3	37	48.3	104	49.1	51	72	31
Өмнөд Африк	37.3	84	53.4	40	84.8	38	36.5	102	111	109
Перу	24.5	128	18.8	36	86.52	35	35.4	109	65	120
Египет	36.9	87	45.8	64	53.9	99	47.8	57	70	34
Босниа	19.8	135	19.6	134	43.3	109	18.7	137	135	135
Ливан	33.8	102	33.7	104	44.4	107	27.1	127	124	125
Монгол	33.3	104	31.7	112	73.6	62	25.6	128	121	129

Эх сурвалж: Олон улсын өрсөлдөх чадварын тайлан, Дэлхийн эдийн засгийн форум 2018


Засгийн газрын бодлогын дарамт өндөртэйгөөс гадна түүхий эдийн үнэ болон уул уурхайн томоохон төслөөс ихээхэн хамааралтай тул хэлбэлзэл өндөртэй байдаг /Зураг 13 болон Зураг 14/. Тухайлбал, 2018 оны байдлаар уул уурхайн болон уурхайгаас хамаарал өндөртэй салбарууд ДНБ-ий 50 орчим хувийг эзэлж байна. Иймд эрдэс бүтээгдэхүүний гадаад эрэлт, үнэ буурахад засгийн газар тэрхүү сөрөг нөлөөг нөхөхийн тулд төсвийн тэлэх бодлого явуулдаг нь гадаад өр огцом нэмэгдэхэд нөлөөлсөн. Тухайлбал, түүхий эдийн үнэ унахад эдийн засгийг дэмжих зорилгоор төсвийн тэлэх бодлого барьсан, 2016 оны сонгуультай холбоотойгоор төсвийн зардал өссөн зэргээс шалтгаалж засгийн газрын өрийн түвшин огцом нэмэгдэж, төгрөгийн ханш суларсан (IMF, 2017).

Зураг 13. ГШХО болон ДНБ



Эх сурвалж: YCX


Зураг 14. ДНБ-д эзлэх хувь, салбараар



Эх сурвалж: YCX


Экспортын үнэ буурсны зэрэгцээ ГШХО татарсан 2013-14 онуудад эдийн засгийн идэвхжил буурч, төсвийн орлого төлөвлөсөн хэмжээнд хүрэлгүй төсвийн алдагдал үүсч, өр нэмэгдэх нэг шалтгаан болсон юм /Зураг 15/. Өр нэмэгдсэнээс шалтгаалж өрийн ДНБ-д эзлэх хувь түүхэнд байгаагүй өндөр хэмжээнд хүрч, зээлийн үйлчилгээний төлбөр төсвийн орлогын 10 гаруй хувийг эзлэх болсон. Бусад улсуудтай харьцуулан харахад ч манай улсын өрийн ДНБ-д эзлэх хувь сүүлийн жилүүдэд огцом өсч хамгийн өндөр болсон байна /Зураг 16/. Энэ нь засгийн газрын бодлого түүхий эдийн үнээс өндөр хамааралтай байгааг илтгэж байна.

Зураг 15. Төсвийн тэнцэл, ДНБ-ий %



Эх сурвалж: Дэлхийн банк

Зураг 16. ЗГ-н өр, ДНБ-д эзлэх хувиар



Эх сурвалж: Дэлхийн банк

Түүнчлэн, бодлогын уялдаа холбоо муутай, тогтворгүй төрийн бодлого нь эдийн засгийн өсөлтөд саад болж байна. Тухайлбал, Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтын зохицуулах тухай хууль 2012 оны 5-р сард батлагдсан бөгөөд уул уурхай, санхүү, болон хэвлэл мэдээлэл, харилцаа холбоо гэсэн стратегийн салбаруудын хувьд гадаадын хөрөнгө оруулагч нийт хувьцааны 49-өөс дээш хувийг эзэмшиж, оруулж байгаа хөрөнгө оруулалтын хэмжээ нь 100 тэрбум төгрөгөөс давсан тохиолдолд Засгийн газрын танилцуулгыг үндэслэл УИХ уг хөрөнгө оруулалтыг зөвшөөрөх эсэх шийдвэр гаргах болсон. Үүнтэй холбоотойгоор Монгол улсын хөрөнгө оруулалтын орчин тогтворгүй болж ГШХО үлэмж буурч, эдийн засгийн байдлыг доройтуулах эрсдэл болсон. Ийнхүү 2012 онд баталсан хуулиа 2013 онд дахин өөрчлөх болсон байдаг (Дэлхийн банк, 2013). Энэ бүхнээс дүгнэхэд эдийн засаг төрөлжөөгүй нь засгийн газрын бодлогод хүндрэл учруулдаг, харин уялдаа холбоо багатай, тогтворгүй төрийн бодлого нь макро эдийн засгийн тогтвортой байдлыг алдагдуулж хөрөнгө оруулалтын өгөөжийг бууруулж байна.

1.2.2.1 Өөрийгөө нээн хөгжүүлэх байдал

Энэ бүлэгт дотоодын аж ахуй нэгж байгууллагууд, иргэд шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлдвэрлэдэг бүтээгдэхүүнийхээ нэр төрлийг нэмэгдүүлэх санаачилга хэр хэмжээнд байгааг авч үзнэ. Тус үзүүлэлтийг манай орны эдийн засгийн төрөлжилт хэр байгаа, экспортолж буй бараа бүтээгдэхүүний нэр төрөл хэр олширч байгаа зэргээс харах боломжтой. Хэрэв тухайн улсын иргэд, аж ахуй нэгжүүд шинэ зүйлийг турших, нээн илрүүлэх (шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх, шинэ технологи нэвтрүүлэх) сонирхол, боломж өндөр байвал эдийн засгийн нэг салбараас хамаарах байдал буурч, улмаар экспорт төрөлжих юм.


Монгол улсын экспортын бүтцийг голлох салбаруудаар ангилан харвал уул уурхайн салбарын экспорт сүүлийн жилүүдэд нийт экспортын 90 орчим хувийг дангаар бүрдүүлж багаа бөгөөд энэ нөхцөл байдал төдийлөн өөрчлөгдөхгүй байна. Түүнчлэн эдийн засгийн төрөлжилтийг илтгэдэг ECI¹⁴-ийг авч үзвэл манай орны төрөлжилт төдийлөн сайжраагүй байна¹⁵. Өөрөөр хэлбэл, экспортын салбарт шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэмэгдэхгүй, нэмэгдсэн ч төдийлөн амжилтанд хүрэхгүй байгааг илтгэж байна /Зураг 18/.

Нөгөөтэйгүүр, худалдааны нөхцөл болон эдийн засгийн өсөлтийн хоорондын корреляци хамаарлыг тооцоход 0.45 байна /Зураг 19/. Нээлттэй жижиг эдийн засагтай манай орны хувьд эдгээр үзүүлэлтүүд өндөр хамааралтай байх нь эдийн засаг дотоодоос илүү гадаад секторт түшиглэж буйг харуулна.

¹⁴ Economic complexity index


¹⁵ Эдийн засгийн төрөлжилтийн үзүүлэлтийг бусад орнуудтай харьцуулан авч үзвэл 1995 оны байдлаар манай орон нийт 129 орноос 93-р байранд жагсаж байсан бол 2017 оны байдлаар 113-р байранд жагсаж байна.

Зураг 18. Монгол улсын экспортын бүтэц, салбаруудаар



Эх үүсвэр: Гаалийн ерөнхий газар


Зураг 19. Худалдааны нөхцөл болон эдийн засгийн өсөлтийн хамаарал



Эх үүсвэр: Монголбанк, YCX

Түүнчлэн эдийн засгийн салбараар хөрөнгө оруулалтыг задалж харвал уул уурхай, уул уурхайгаас хамаарал өндөртэй салбаруудын хөрөнгө оруулалт нийт хөрөнгө оруулалтад дийлэнх хувийг эзэлж байна /Зураг 20/.

Зураг 20. Хөрөнгө оруулалт, салбараар (2018)



Эх сурвалж: YCX

Өөрөөр хэлбэл, хөрөнгө оруулагчид уул уурхайгаас бусад салбарт бага ач холбогдол өгч байгаа нь эдийн засаг төрөлжихгүй байгаад голлон нөлөөлж байна. Эндээс бид цаашид эдийн засгаа солонгоруулах, дотоодын үйлдвэрлэлээ дэмжих шаардлага байгаа нь тодорхой харагдаж байна. Иймд мэдээллийн дам нөлөө эдийн засгийн өсөлтөд саад болж буй томоохон хүчин зүйл мөн юм.

1.2.2.2 Зохицуулалтын алдаа

Дотоодын аж ахуй нэгжүүд болон олон улсын холбоотнуудтай уялдсан хууль, эрх зүйн зохицуулалт хийх, төрийн бодлого боловсруулж хэрэгжүүлэх нь зах зээлд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлэх сэдлийг нэмэгдүүлдэг. Жишээлбэл, зарим улс орнуудад шинээр үйлдвэрлэл эрхэлж буй аж ахуй нэгжүүдэд татаас өгөх байдлаар тодорхой секторыг дэмждэг байна.


Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн огторгуй

Энэхүү ойлголтын талаарх анхны өгүүлэл "The Product Space Conditions the Development of Nations" нэртэйгээр Science сэтгүүлд 2007 онд хэвлэгджээ. Хаусманн болон бусад судлаачдын бичсэн тус өгүүллийн гол санааг дор тайлбарлалаа.

Хэрэв энэ дэлхий дээр үйлдвэрлэгдэж буй бүтээгдэхүүн бүрийг нэгжээд мод хэмээн сэтгэвэл нийт үйлдвэрлэгдэж буй бүтээгдэхүүнийг ойтой зүйрлэн бодож болно. Тухайн ойд хоорондоо ойрхон оршиж буй моднууд нь үйлдвэрлэх аргачлалын хувьд ижил төстэй бүтээгдэхүүнүүдийг илэрхийлнэ. Үүний зэрэгцээ бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг ойд буй сармагчинтай зүйрлэн үзвэл тэдгээр сармагчингууд өөрт ойр буй мөчир рүү үсрэхээс, олон мод алгасаж үсэрч чадахгүй. Энэ нь бүтээгдэхүүн үйлдвэрлэгч одоо үйлдвэрлэж чадаж байгаа нөөцөө ашиглан дараагийн түүнтэй ойролцоо бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх боломжтойг илэрхийлнэ. Аливаа бүтээгдэхүүнийг хэрхэн хийхээ мэдэхгүй бол тухайн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх боломжгүй. Нөөц нь огт байхгүй (хүмүүн капитал, технологи зэрэг) зүйлийг хийхэд маш өндөр зардалтай. Энэхүү таамаглалд үндэслэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн огторгуйн ойг зурсан бөгөөд улс орон бүрийн хувьд юу үйлдвэрлэж буйгаас хамааран ялгаатай зурагддаг. Цэг бүр тодорхой нэг бүтээгдэхүүнийг илэрхийлэх бөгөөд цэгийн хэмжээ нь тухайн бүтээгдэхүүний нийт үнийн дүнг илэрхийлнэ. Өөрөөр хэлбэл, ямар нэг цэг бусад цэгээс том байх нь нийт дэлхийн үйлдвэрлэлд том жин эзэлж буйг илэрхийлнэ. Иймд өөрийн орны бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн орон зайг жилээс жилд харьцуулан харах нь манай орны экспортын өрсөлдөх

чадвар хэрхэн өөрчлөгдөж байгаа, бүтээгдэхүүн үйлдвэрлэл хэр төрөлжиж байгаа зэргийг шинжлэхэд чухал ач холбогдолтой.

Зураг 21. Монгол улсын бүтээгдэхүүний огторгуй, 2017 он




Эх сурвалж: <https://atlas.media.mit.edu/en/visualize/network/sitc/pgi/mng/all/show/2017>
Монгол улсын экспортын бүтээгдэхүүний огторгуйг харвал ихэвчлэн ойн зах хэсгээр байршдаг бөгөөд энэ хандлага сүүлийн жилүүдэд төдийлөн өөрчлөгдөөгүй. Ойн зах хэсгээр байршина гэдэг нь одоо үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнээс дамжаад дараагийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх боломж хомс байгааг илтгэнэ. Өөрөөр хэлбэл, манай экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэгч өөрийн үйлдвэрлэж байгаагаас өөр нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхгүй байна. Энэ нь манай экспортын бүтээгдэхүүний ихэнх хэсгийг уул уурхайн боловсруулаагүй түүхий эд эзэлж буйтай холбоотой юм. Тиймээс цаашид тус ойн гүн рүү чиглэсэн бодлого явуулбал манай улсын экспортын бүтээгдэхүүний төрөлжилт нэмэгдэх, уул уурхайн түүхий эдээс хамаарах хамаарлыг бууруулах боломж бүрдэнэ.

Шийдвэрийн горимын баруун тал

Хөрөнгө оруулалтын өгөөж өндөр, аж ахуй нэгж байгууллагууд болон иргэд эдийн засагт хөрөнгө оруулах сонирхол өндөр байсан ч санхүүжилт авах боломж муу байвал эдийн засаг потенциал хэмжээнд өсөх боломжгүй болдог.


Манай орны санхүүжилт авах бололцоо сайжирч, хувийн секторт олгосон зээлийн хэмжээ 1997 оноос хойш огцом нэмэгджээ. Энэ нь “Бизнес эрхлэхүй (2019)” судалгааны үр дүнтэй нийцтэй байна. Хэдийгээр хувийн секторт олгосон зээлийн хэмжээ ийнхүү нэмэгдсэн ч зээлийн бодит хүү харьцангуй өндөр байгаа нь зээл авах эрэлт их байгаа ч санхүүжилтийн өртөг өндөртэйг илтгэж байна.

Зураг 22. Хувийн секторт олгосон зээл, ДНБ-д эзлэх хувиар



Эх сурвалж: Дэлхийн банк

Зураг 23. Зээлийн бодит хүү



Эх сурвалж: Дэлхийн банк

Санхүүжилтийн зардал өндөр байгаа нь дараах 2 хүчин зүйлээс хамаардаг. Үүнд:


- Олон улсаас санхүүжилт авах зардал өндөр байх. Хэрэв дотоодын хадгаламжийн түвшин бага тохиолдолд дотоодын санхүүгийн байгууллагуудын эх үүсвэр дутагдаж, шаардлагатай хэмжээнд зээл олгох боломжгүй болдог. Иймд хүмүүс зөвхөн дотоод захаас гэлтгүй гадаад захаас санхүүжилт эрэлхийлдэг ч тухайн улсын зээлжих зэрэглэл муу, зээлээ төлөхгүй байх эрсдэл өндөр бол олон улсын санхүүжилт татах магадлал муу байдаг нь эдийн засгийн өсөлтөд саад болдог.
- Дотоодын санхүүжилтийн зардал өндөр байх. Хоёрдугаарт, хадгаламжийн түвшин өндөр, санхүүгийн байгууллагуудын эх үүсвэр хангалттай хэмжээнд байсан ч дотоодын санхүүгийн

зуучлал муу, санхүүгийн салбарын үйлчилгээний хүртээмж багатай тохиолдолд эдийн засгийн өсөлтийг чөдөрлөдөг байна.

2.1 Олон улсын захаас санхүүжилт татах боломж

Засгийн газрын өр огцом нэмэгдсэн нь олон улсын захаас санхүүжилт татах бололцоог бууруулж байна. Тухайлбал, манай орны хувьд 2010 оноос хойш засгийн газар томоохон дүнтэй 4 бонд, Хөгжлийн банк томоохон дүнтэй 2 бонд, бусад аж ахуй нэгжүүд хэд хэдэн өндөр дүнтэй бондыг олон улсын захад гаргасан байдаг. Улмаар сүүлийн жилүүдэд манай улс гадаад захаас санхүүжилт авахад өртөг өндөртэй, илүү хүндрэлтэй болжээ¹⁶. Олон улсын зээлжих зэрэглэл тогтоох байгууллагуудаас Монгол улсад өгч буй зээлжих зэрэглэлийн үнэлгээнүүд хоорондоо нийцтэй байгаа бөгөөд энэхүү судалгаанд ашигласан Мүүдиз (Moody's) агентлагийн гаргасан үр дүнгээр манай орны зээлжих зэрэглэл 2014 оноос хойш муу үнэлгээтэй байна.

Зураг 24. Мүүдиз агентлагийн Монгол орны зээлжих зэрэглэлийн үнэлгээ



Эх сурвалж: Moody's агентлаг

Хүснэгт 8. Монгол улсын олон улсын захад гаргасан бондууд

Бонд гаргагч	Бондын нэр	Нийт дүн	Гаргасан огноо
Засгийн газар	Чингис	1 тэрбум доллар	12/5/2012
	Мазаалай	500 сая доллар	4/6/2016
	Хуралдай	600 сая доллар	3/9/2017
	Гэрэгэ	800 сая доллар	11/1/2017
Хөгжлийн банк	Самурай	30 тэрбум иен	12/25/2013
	DBM	500 сая доллар	10/23/2018
Арилжааны банк	ХХБ	500 сая доллар	5/19/2015
	ER	412 сая доллар	5/4/2017


¹⁶ Манай орны зээлжих зэрэглэл 2014 оноос муу үнэлгээтэй хэвээр байгаа нь гадаад захаас санхүүжилт авахад өртөг өндөртэй, илүү хүндрэлтэй болсонг илтгэж байна.

Энержи Ресурс	Шинэ бонд	440 сая доллар	4/15/2019
Анд Глобал		250 сая доллар	1/29/2019
МИК		50 сая доллар	2/12/2019

Монгол улсын зээлжих зэрэглэл 2014 онд В1- ангилалд байсан бөгөөд үүнээс хойш удаа дараа муудсаар В3 зэрэглэл хүрсэн. Тодруулбал, 2014 онд Монгол улсын гадаад валютын нөөц огцом буурч, зээлийн хэмжээ огцом өссөн шалтгаанаар зээлжих зэрэглэлийг В1- гэсэн үнэлгээнээс В2- болгож бууруулсан байдаг. Улмаар төсвийн алдагдал өндөр, бондын төлөлт болон эдийн засгийн өсөлт хангалтгүй, төгрөгийн ханш огцом суларсан зэрэг шалтгаанаар 2016, 2017 онуудад зээлжих зэрэглэлийг В3 болон САА1 ангилал руу дараалан буулгасан юм. Харин 2018 онд уул уурхайн томоохон төсөл хөтөлбөрүүд амжилттай хэрэгжсэнээр эдийн засаг сэргэх, улсын төсөв, гадаад төлбөрийн чадвар огцом сайжрах хүлээлттэй байгаа гэсэн шалтгаанаар Мүүдиз агентлаг манай орны зээлжих зэрэглэлийг сайжруулж В3 болгосон /Зураг 24/. Хэдий тийм ч В3 үнэлгээ нь муу үнэлгээ юм.

Олон улсын захаас **Зураг 25. Гадаадын шууд хөрөнгө оруулалт**

хөрөнгө татах өөр нэг чухал эх үүсвэр нь гадаадын шууд хөрөнгө оруулалт байдаг. Манай орны гадаадын шууд хөрөнгө оруулалт харьцангуй өндөр байгаа ч мөчлөг дагасан шинжтэй байна.



Эх сурвалж: Монголбанк


Түүнчлэн ГШХО-ын дийлэнх буюу 70 орчим хувь нь уул уурхайн салбарт хийгддэг бол үлдсэн 30 хувийн дийлэнх нь худалдаа (7.4%), банк санхүү (4.8%), барилга (4.3%), үйлчилгээ (3.6%)-ний салбаруудад

зарцуулагдаж байна. Үүнээс үзэхэд гадны хөрөнгө оруулагчид уул уурхайгаас бусад салбарыг төдийлөн сонирхохгүй байна.

2.2.1 Хадгаламж


Дотоодын хадгаламжийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2000 оноос 2006 оныг хүртэл 17%-аас 46% хүртэл өссөн нь тус хугацаанд худалдааны нөхцөл таатай байсан, уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт болон үйл ажиллагаа эрчимжсэн, аялал жуучлалын орлого болон гадаадаас манай улс руу шилжүүлэх мөнгөн шилжүүлэг нэмэгдсэн зэргээс шалтгаалсан. Харин 2007 оноос дэлхийн эдийн засгийн хямрал эхэлж, гадаад эрэлт муудсанаар манай орны эдийн засгийн өсөлт удааширч, худалдааны нөхцөл муудаж, хөрөнгө оруулалт огцом унасан. Улмаар 2009 он гэхэд хадгаламжийн түвшин 27.2%-д хүртэл буурчээ. 2009 оноос худалдааны нөхцөл сайжирч, 2010 оноос Оюу толгойн хөрөнгө оруулалт хийгдэж эхэлснээр эдийн засаг сэргэж, хадгаламжийн түвшин бага зэрэг нэмэгдсэн ч 2012 оноос 2016 оныг хүртэл өрхийн орлогын өсөлт саарч эхэлснээс шалтгаалж хадгаламжийн түвшин буурчээ /Зураг 26/. Энэхүү эдийн засгийн мөчлөгийг дагасан, тогтворгүй хадгаламжийн түвшин нь банкны эх үүсвэрт томоохон тодорхой бус байдал үүсгэж, банкны салбарын зээл олгох боломжийг бууруулдаг.

Зураг 26. Хадгаламжийн түвшин (ДНБ-д эзлэх %-иар)



Эх сурвалж: Дэлхийн банк

Зураг 27. Өрхийн орлого болон зарлагын өсөлт




Эх сурвалж: YCX

Дотоодын хадгаламжийн түвшин (ДНБ-ий 25 орчим хувьтай тэнцэнэ) харьцуулж буй орнуудын ихэнхээс өндөр байна. Хэдий тийм ч хадгаламжийн түвшин нь мөчлөг дагасан үзүүлэлт тул хэлбэлзэл өндөртэй байна. Өөрөөр хэлбэл, гадаад шокоос өндөр хамааралтай манай орны хувьд эдийн засгийн хэлбэлзэл өндөр байдаг тул хадгаламжийн тогтворгүй байдлыг арилгахын тулд эдийн засгийн гадаад сектороос хамаарах хамаарлыг бууруулах шаардлагатай юм. Дотоодын хадгаламжийн түвшин (ДНБ-ий 25 орчим хувийг эзэлдэг) харьцуулж буй орнуудын ихэнхээс өндөр байгаа хэдий ч хэлбэлзэл өндөртэй, мөн хүн амын тоо бага байгаагаас шалтгаалж хадгаламжийн хэмжээ бага байгаа нь томоохон төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхэд хүрэлцдэггүй.

2.2.2 Санхүүгийн зуучлал

Манай оронд нийт 13 арилжааны банк үйл ажиллагаа явуулж байгаагийн хамгийн том 5 банк нийт активын 85 орчим хувийг эзэлдэг нь бусад орнуудаас харьцангуй өндөр үзүүлэлт юм /Зураг 28/. Банкны салбарын төвлөрлийг тооцож харвал манай улсад төвлөрөл өндөр, системийн томоохон банкнууд өндөр нөлөөтэй байна. Банкны салбарын төвлөрлийг Херфиндаль-Хиршман индексээр тооцоход манай банкны систем төвлөрөл өндөр байгааг батлан харуулж байна /Зураг 29/. Банкны салбарт төвлөрөл өндөртэй байх нь эдийн засгийн хүндрэлийн үед системийн ач холбогдолтой банкуудад эрсдэл хуримтлагдах, цаашилбал банкны салбарт хямрал үүсэх эрсдэлийг нэмэгдүүлдэг.

Зураг 28. Хамгийн том 5 банкны нийт активт эзлэх хувь



Эх сурвалж: Дэлхийн банк

Зураг 29. Банкны салбарын төвлөрлийн үзүүлэлт

Монгол орны хувьд	
Post-merger NHI	3008.5
Pre-merger NHI	1736.5
Delta	1272

Энд:

	Delta<100	Delta нь 100-200 хооронд	Delta>200
Post-Merger NHI<1500	Өрсөлдөөнд хохирол учруулахгүй	Өрсөлдөөнд хохирол учруулахгүй	Өрсөлдөөнд хохирол учруулахгүй
Post-Merger NHI нь 1500-2500-н хооронд	Өрсөлдөөнд хохирол учруулахгүй	Өрсөлдөөнд хохирол учруулах боломжтой	Өрсөлдөөнд хохирол учруулах боломжтой
Post-Merger NHI>2500	Өрсөлдөөнд хохирол учруулахгүй	Өрсөлдөөнд хохирол учруулах боломжтой	Төвлөрөл өндөртэй

Эх сурвалж: Судлаачийн тооцоо


Хэдийгээр банкны салбарын төвлөрөл өндөр байгаа ч банкны салбарын ашиг харьцангуй бага түвшинд байна /Зураг 30, 31/. Бусад орнуудтай харьцуулахад манай орны банкны салбарын ашиг сүүлийн жилүүдэд огцом буурсан, мөн зээлийн бодит хүү 2013 оноос хойш буурсан. Түүнчлэн банкны салбарт хийгдэж буй шинэчлэлтэй холбоотойгоор зээл авахад илүү хялбар болсоор байна. Эдгээр үзүүлэлт нь “Дэлхийн өрсөлдөх чадварын тайлан”-гуудын үр дүнтэй нийцтэй байгаа юм.

Зураг 30. Хүүгийн цэвэр маржин, (%)



Эх сурвалж: Дэлхийн банк

Зураг 31. Активын өгөөж, (%)



Эх сурвалж: Дэлхийн банк

Манай эдийн засагт зээлийн хүү нь хөрөнгө оруулалт, бизнес эрхлэлтийг дэмжих түвшин хүртэл буурахгүй байгаа талаар сүүлийн 10 гаруй жилийн турш байнга ярьж, холбогдох бодлогын баримт бичиг боловсруулагдан хэрэгжсэн хэдий ч зээлийн хүү өндөр хэвээр байна (Д.Ган-Очир, Монголын эдийн засаг дахь зээлийн хүүний оньсыг тайлах нь, 2016).

Зураг 32. Хүүгийн зөрүү



Эх сурвалж: Монголбанк

Зээлийн хүү ийм өндөр түвшинд байгаа нь хадгаламжийн хүү өндөр байгаагаас голлон шалтгаалж байгаа юм¹⁷. Зээлийн хүү ийм өндөр түвшинд тогтох нь санхүүжилтийн зардлыг нэмэгдүүлж, эдийн засгийн өсөлтөд саад болдог.

Хүснэгт 9. Зээлийн бодит хүү, улсуудаар

Улсын нэр	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Армен	10.6	12.9	11.3	12.2	13.8	16.2	17.0	12.0	10.0
Босния	6.4	4.9	6.5	7.3	5.6	4.4	3.8	2.6	2.4
Боливи	1.0	-3.2	3.8	4.8	7.5	13.3	9.4	1.9	4.8
Доминикан	6.3	6.9	9.9	8.5	11.6	14.1	14.1	11.3	
Египет	0.8	-0.6	-6.3	3.3	0.4	1.5	6.9	-3.9	-2.6
Иордан	0.7	2.3	4.3	3.1	4.8	5.6	6.7	6.6	6.8
Киргиз	12.4	1.1	13.1	17.6	10.8	19.6	17.4	12.6	17.8
Ливан	8.1	4.0	-0.2	4.0	6.1	3.9	7.4	4.5	3.0
Монгол	-13.7	1.3	4.7	15.1	10.8	17.5	17.1	8.5	9.2
Пакистан	2.9	-4.4	7.1	4.7	4.0	5.8	8.3	4.0	6.3
Перу	12.5	11.2	17.8	16.9	12.9	13.2	13.0		
Сенегал	4.0	1.7	2.4	5.2	7.6	4.0	4.3	3.5	
Эсватини	6.3	3.5	0.6	3.8	2.6	1.4	4.0	7.2	5.4
Өмнөд Африк	3.3	2.3	3.3	2.2	3.4	4.1	3.5	4.6	6.3

Эх сурвалж: Дэлхийн банк

Эцэст нь зээлийн хүү өндөр байгаа нь эдийн засгийн өсөлтөд дараа болж байна. Зээлийн хүүг бууруулахад хадгаламжийн хүүг бууруулах нь чухал ач холбогдолтой. Харин өндөр, тогтворгүй инфляцийн орчин, үнийн хүчтэй өрсөлдөөн, төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн сулрал, түүний хүлээлт болон зах зээлийн өндөр эрсдэл зэрэг нь хадгаламжийн хүү өндөр байх нөхцөл болдог байна (Д.Ган-Очир, Арилжааны банкуудын зээл болон хадгаламжийн хүүнд нөлөөлж буй хүчин зүйлс, 2009). Үүнээс үзэхэд зээлийн хүүг бууруулахад макро эдийн засгийн


¹⁷ Д.Энхзаяа, Л.Дөлгөөн, Д.Даваасүх (2014), Д.Ган-Очир (2016) нар зээлийн хүүг бууруулахад хадгаламжийн хүүг бууруулах чухал ач холбогдолтой талаар дурдсан байдаг.

орчинг тогтворжуулах, сайжруулах явдал нэн тэргүүний асуудал болох нь харагдаж байна.

4.4 Өрсөлдөх чадвар сайтай орнуудтай¹⁸ харьцуулсан шинжилгээ

Судалгааны ажлын өмнөх хэсгүүдэд ойролцоо орнуудын дундажтай харьцуулах байдлаар сайжруулах шаардлагатай үзүүлэлтээ тодорхойлсон хэдий ч тэдгээр үзүүлэлтийн дундаж мөн адил муу байсан тохиолдолд зарим үзүүлэлтийг орхигдуулах эрсдэлтэй тул энэхүү бүлгийг нэмж оруулсан. Ерөнхийдөө ихэнх үзүүлэлтүүдийн хувьд бусад орнуудтай ойролцоо үр дүнтэй гарсан хэдий ч харьцангуй өндөр хөгжилтэй орнуудаас Монгол улсын өрсөлдөх чадвар муу байна /Зураг 33/.

Зураг 33. Монгол улсын өрсөлдөх чадварын үзүүлэлтүүд, өрсөлдөх чадвар сайтай орнуудтай харьцуулснаар (оноогоор)



Эх сурвалж: Дэлхийн өрсөлдөх чадварын тайлан 2018-19

¹⁸ Хөгжил илүү орнуудыг сонгохдоо харьцуулж буй улсууд дундаас сонгосон.

Дэлхийн өрсөлдөх чадварын тайланд эдийн засгийн өрсөлдөх чадварыг хэмждэг 12 үндсэн үзүүлэлтийг тооцдог. Эдгээр үзүүлэлтүүдийг нэг бүрчлэн харвал Монгол улс хөдөлмөрийн захаас бусад бүх үзүүлэлтээр хангалтгүй үнэлгээтэй байна. Тухайлбал институцийн чанар (80-р байр), эрүүл мэнд (105-р байр), бүтээгдэхүүний зах зээл (108-р байр), интернэт ашиглах боломж (115-р байр), бизнесийн идэвхжил (89-р байр) зэрэг үзүүлэлтүүдийг онцолж болохоор байна.

Манай улсын институцийн чанар харьцангуй муу байгаа нь өмнөх хэсгүүдэд дурдагдсан авлига, өмчийн эрх, бодлогын дарамтын үзүүлэлтүүдээс гадна шүүх засаглалын хараат бус байдал (113-р байр), аудит нягтлан бодох бүртгэлийн чанар (126-р байр) зэргээс шалтгаалж байна. Харин бүтээгдэхүүний зах зээл муу байхад дотоодын өрсөлдөөн муу (133-р байр), гадаад худалдааны татварын бус дарамт өндөр (108-р байр) зэрэг үзүүлэлтүүд нөлөөлж байна. Тиймээс энэ бүлэгт дурдагдсан бусад асуудлуудыг шийдвэрлэх, сайжруулах нь чухал ач холбогдолтой.

5. ДҮГНЭЛТ, САНАЛ

Энэхүү судалгаагаар HRV аргачлалыг ашиглаж Монгол улсын эдийн засгийн өсөлтөд ямар хүчин зүйл саад болж байгаа талаар авч үзлээ. HRV аргачлалд хөрөнгө оруулалт нэмэгдэх нь эдийн засгийн өсөлтийг тэтгэдэг гэсэн үндсэн таамаглал тавьдаг. Харин хөрөнгө оруулалт бага байх нь i) хөрөнгө оруулалтын өгөөж бага байх ii) хөрөнгө оруулалтын зардал өндөр байх гэсэн 2 үндсэн шалтгаантай байна. Улмаар шинжилгээний үр дүнгээс харахад манай улсын хөрөнгө оруулалтын зардал болон өгөөж аль аль нь хөрөнгө оруулалт бага байхад нөлөөлж байна.

Шинжилгээний үр дүнд манай орны хувьд хөрөнгө оруулалтын өгөөж бага, мөн санхүүжилтын зардал өндөр байна. Хөрөнгө оруулалтын өгөөж бага байхад бүтээмж нэмэгдэхгүй байгаа, дэд бүтэц муутай, авилга өндөр, өмчийн эрхийг хамгаалах байдал муу, бодлогын дарамт өндөртэй, бүтээгдэхүүний захын хэмжээ бага, эдийн засаг төрөлжихгүй байгаа гэсэн хүчин зүйлүүд голлон нөлөөлж байна. Харин хөрөнгө оруулалтын зардал өндөр байхад хадгаламжийн түвшин хэлбэлзэл өндөртэй, хэмжээ

багатай, банкны салбарын төвлөрөл өндөртэй, олон улсаас санхүүжилт авах зардал өндөр байгаа нь голлон нөлөөлж байна. Ийнхүү дараах саналыг дэвшүүллээ.

Хөрөнгө оруулалт голлон уул уурхайн салбарыг чиглэж байгаа нь эдийн засгийн төрөлжилтөд сөргөөр нөлөөлж, цаашлаад манай орны эдийн засаг уул уурхайн салбараас өндөр хамааралтай нь маш олон асуудлын гол үндэс болж байна. Эдийн засаг төрөлжихгүй байх нь гадаад шокоос мэдрэг байдлыг нэмэгдүүлж, бодлогын тогтворгүй байдалд хүргэж, банкны салбарын гол эх үүсвэр болох хадгаламжийн хүү өсөхөд нөлөөлж байна. Бодлогын тогтворгүй байдал нь гадаад валютын нөөцөд сөргөөр нөлөөлж, гадаад санхүүжилтын зардлыг нэмэгдүүлж, хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулах сонирхлыг бууруулж байна. Иймд уул уурхайгаас бусад салбарын хөгжлийг дэмжих нь санхүүжилтын зардлыг бууруулах, хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой.

Түүнчлэн манай орны эдийн засгийн өсөлт голлон биет хөрөнгийн хуримтлалаас бий болж байгаа бөгөөд бүтээмж төдийлөн нэмэгдэхгүй байгааг энд онцлон дурдах хэрэгтэй. Боловсролын салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх гэхээс илүү чанарыг нэмэгдүүлж бүтээмжийг нэмэгдүүлэх нь эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх, уул уурхайн бус салбарын санхүүжилтыг нэмэгдүүлэхэд үр нөлөөтэй.

Дэд бүтцийг шинэчлэн хөгжүүлэх нь уул уурхайн болон бусад аж үйлдвэрийн эрэлтийг хангах, эрдэс бүтээгдэхүүний экспортыг хөнгөвчлөх, уул уурхайн бус салбарын хөгжлийг дэмжих чухал ач холбогдолтой байна.

Өмчийн эрхийг хамгаалах, авлигын түвшинг бууруулах нь бүтээгдэхүүний зах зээлийн хэмжээг нэмэгдүүлэх, төрөлжилтийг нэмэгдүүлэх, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад чухал үр нөлөөтэй.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- ❖ Robert J.Barro (1999), Human capital and growth in cross-country regressions
- ❖ OECD (2001), OECD Manual Measuring Productivity Measurement of aggregate and industry-level productivity growth
- ❖ Ricardo Hausmann, Bailey Klinger, Rodrigo Wagner (2008), Doing Growth Diagnostics in Practice: A ‘Mindbook’ CID Working paper No. 177
- ❖ Ariel BenYishay, Franck S. Weibe, (2010), “Diagnostics in Transition: Analysing the constraints to economic growth in Moldova”
- ❖ Sara Calvo, (2006), “Applying the Growth Diagnostics Approach: the Case of Bolivia”
- ❖ Yaroslava Babych , Michael Fuenfzig, (2012), “An Applicatio of the Growth Diagnostics Framework: The Case of Georgia”
- ❖ Elena Ianchovichina, Sudarshan Gooptu,(2007), “Growth Diagnostics for a Resource-Rich Transition Economy: The Case of Mongolia”
- ❖ Ortrun Merkle, (2018), Transparency International, “Anti – Corruption Helpdesk”
- ❖ Ricardo Hausmann, Bailey Klinger (2008), Growth Diagnostics in Peru
- ❖ World Economic Forum, “The Global Competitiveness reports”
- ❖ World bank (2018), Mongolia Economic Update
- ❖ The Heritage Foundation, The Index of Economic Freedom (2018)
- ❖ Transparency International (2018), Mongolia: Overview of corruption and anti-corruption
- ❖ KPMG (2016), Mongolia Tax Profile
- ❖ Millennium Challenge Corporation (2016), Mongolia constraints analysis
- ❖ United States Agency International Development (2010), Mongolia economic growth assessment
- ❖ United Nations Development Programme – Human Development Index
- ❖ World Bank Enterprise Surveys
- ❖ World Bank Doing Business Indicators
- ❖ Global Competitiveness Report
- ❖ Transparency International Corruption Perceptions Index
- ❖ World Bank Worldwide Governance Indicators

- ❖ Д.Энхзаяа, Л.Дөлгөөн, Д.Даваасүх (2014), Банкны зээлийн хүүг бууруулах боломж
- ❖ Д.Ган-Очир (2016), Монголын эдийн засаг дахь зээлийн өндөр хүүний оньсогыг тайлах нь
- ❖ IMF (2017), IMF article IV: Mongolia

ХАВСРАЈТ

Хавсралт 1. Хөрөнгө оруулалтад нөлөөлж буй гол хүчин зүйлүүдийн динамик

Үзүүлэлт	Хэмжигнэгж	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017		Тайлбар*
Хөрөнгө оруулалтын өгөөж бага											
Нийгмийн өгөөж бага											
Боловсролын системийн чанар	эрэмбэ	136	132	136	137	116	111	109	116		↑
Дэд бүтэц	эрэмбэ	137	136	137	133	119	107	110	108		↑
Өгөөжийн эрсдэл өндөр											
Микро эрсдэл											
Өмчийн эрх	эрэмбэ	115	118	118	110	100	111	110	112		↑
Авилга	эрэмбэ	120	116	120	94	83	80	72	87		↑
Татвар	оноо	4	2.9	3.4	3.1	6.4	5.7	7.9	6.8		↓
Макро эрсдэл											
Макро эдийн засгийн орчин	оноо	4.9	4.9	4.9	3.7	3.8	3.2	3.6	4.4		↓
Бодлогын тогтворгүй байдал	оноо	9.5	9.5	6.4	10.2	9.1	8.3	10.1	10.5		↓
Бодлогын ил тод байдал	эрэмбэ	120	114	102	105	87	69	72	93		↑
Засгийн газрын өр /ДНБ-д эзлэх %/	эзлэххү	31	51.7	63	63	54.7	77.4	79.4	66		↓
Дотоод захын хэмжээ	эрэмбэ	127	127	119	119	120	101	108	108		↑
Гадаад захын хэмжээ	эрэмбэ	113	113	108	115	111	96	98	91		↑
Санхүүжилтийн зардал өндөр											
Олон улсаас санхүүжилт татах боломж /Moody's/	оноо	B1	B1	B1	B1	B2	B2	B3	CAA1		↓
Хөрөнгийн захаас санхүүжих боломж	эрэмбэ	124	107	107	123	116	110	97	103		↑
Хадгаламжийн түвшин	эрэмбэ	4	11	7	33	33	44	59	41		↓
Банкны салбарын эрүүл байдал	эрэмбэ	136	134	121	110	99	119	125	126		↑
Санхүүгийн үйлчилгээний хүртээмж	эрэмбэ	126	124	111	124	111	111		129		=
Санхүүгийн үйлчилгээ авах бололцоо	эрэмбэ	124	122	115	115	119	119	107	112		↑
Зээл авахад хялбар байдал	эрэмбэ	139	136	135	142	143	139	114	121		↑
Тайлбар*: ↑ - үзүүлэлт сайжирсан, ↓ - үзүүлэлт муудсан, = үзүүлэлт хэвээрээ байгаа											